



**ХЭНТИЙ АЙМГИЙН
УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 5/29

Хэрлэн сум

Б.Уранзаяаг ажлаас чөлөөлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.3, 78.1.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гурванбаян сумын харуулын техникч Б.Уранзаяаг туршилтаар ажиллах хугацаандаа албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй учир 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч: С.Батцэнгэл – Хөдөө аж ахуйн цаг уурын судалгаа үйлчилгээ хариуцсан инженер

Гишүүд: П.Наранцэцэг – Мэдээллийн дэд сан, цаг уурын үйлчилгээний инженер

Ц.Түвшинтөгс – Багаж, хэмжилзүйн инженер

3. Тушаалын хэрэгжилтийг биелүүлж, холбогдох тооцоонд хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Нямсүрэн/, хүний нөөцийн ажилтан /Э.Мөнхням/ нарт даалгасугай.

ДАРГА

Б. ХЭРЛЭНЧИМЭГ

